

МАНЖ НАРТ ХОЛБОГДОХ ЗАРИМ ЧУХАЛ НЭРИЙН УТГА, БИЧЛЭГИЙН ТУХАЙД

Э.Мөнх-Учрал

Түлхүүр үг: *Хунтайж, Журчин, зэрлэг жүрчин, Манж, Дайчин*

Удиртгал

Эдүгээ олон хүний санаанд хятадаас өөрцгүйгээр буух болсон манж нар бол жүрчидийн хойчис билээ. Журчин нар Манжуур, Төв ба Зүүн Хятад, Хойд Солонгос, Номхон далайн эрэг орчмоор нутаглаж, газар нутгийнхаа онцлогоос хамааран уул хөндийд нутагтай нь мал аж ахуй, өмнөдийн талынхан газар тариалан, гол ус дагагсад нь загас агнуур эрхэлж, язгуураас бөөгийн шүтлэгтэй, зарим нь хагас нүүдэлчин маягтай аж төрж байжээ.¹

Жүрчидийн Ваньянь аймгийн Агуда Хятан улсыг удаа дараа довтлон доройтуулж, 1115 онд *Алтан улс* (жү. anchun, ма. Aisin gurun, хя. 金 Jin)-ыг байгуулав. Татаруудын барьж ирсэн Монголын Амбагай хааныг алснаар, жүрчин, монгол хоёрын дунд 1150-аад оны дундаас Хутула, Чингис, Өгэдэй гурван хааны үе дамжсан 80 орчим жилийн өсөл хяслын хариу нэхсэн дайн байлдаан өрнөсөөр эцэстээ 1234 онд Алтан улсыг бут цохисноор төгссөн түүхтэй.

Их Монгол Улс, Монголын Эзэнт гүрний мэдэлд байсан цаг үед жүрчин нарт Монголын нөлөө асар ихээр тусаж байсныг Мин Улсын үеийн (хя. 明 Ming, 1368-1644)² баримтаар жишээлэн өгүүлбэл, мөн үеийн жүрчиний гурван гол аймгийн нэгэн болох *Жяньжөү* (хя. 建州 Jianzhou)-д жүрчин бичиг мэдэх хүнгүй болсон тул удирдагчид нь хятад, солонгостой монголоор харилцахыг хүсэж байв (Crossley 1997: 37-38). Нөгөө нэг гол аймаг болох 1444 онд *Хайши* (хя. 海西 Haixi) жүрчиний Шюаньчөн харуулын удирдагч Тотомудару Мин улсын хаанд 40 харуулын жүрчин нараас жүрчин бичиг ойлгох нэг ч хүн үгүй тул хааны зарлигийг монгол бичгээр бичиж өгөөч хэмээж байжээ (Ulrich 2007: 135).

Мин улсын үе, XVI зууны сүүл үеэр Манжуурын жүрчин нар улс төрийн үүднээс, *Жяньжөү*, *Хайши*, *Ежинь* (хя. 野人 Yejin)³ хэмээх гурван гол аймаг болж байжээ (Di Cosmo 2016: 112). *Сүнгари*⁴ буюу Юань, Мин улсын үед *Хайши* хэмээж байсан голын нэрээр нэрлэгдсэн *Хайши жүрчин* болбоос, Шэньян буюу хожим 1625 онд Нурхачи нийслэлээ болгосон Мүгдэний⁵ хойд

¹ Удганыг манжаар *саман* (ма. saman) гэнэ. Өрнө дахинаа бөө удганыг нэрлэсэн *shaman* гэдэг нэрийг энэхүү манж-түнгүсийн хэлний “саман”-аас гаралтай, XVI зууны дундуур Оросоор дамжин өрнөдөд нэвтэрсэн гэж үздэг.

² Хятад хэлний үеийг кириллээр галиглахдаа 2016 онд батлагдсан журмыг баримтлав. <http://ncip.nairuulga.mn/content/41>

³ 人 ханз одоогийн хятад хэлний мандарин аялгуунд *рэнь*, кантон аялгуунд *жань* гэсэн дуудлагатай болжээ.

⁴ *Сүнгари* гол (ма. sungari, хя. 松花江 songhua jiang) нь Хойд Солонгос, Хятадын хилийн ойролцоох Тэнгэр нуурын (ма. tamun omo, хя. 天池 tianchi) зүүн этгээдээс эх аван хойд зүгт урсдаг бөгөөд 1897 км урттай.

⁵ Одоогийн БНХАУ-ын Ляонин мужийн төв Шэньян (沈阳/瀋陽 Shenyang, Шэнь голын наран тал гэсэн утгатай) XVII зуунд Алтан улсын нийслэл байв. Тус хотыг ХТӨ 300-аад оны үед байгуулсан ба Хөү хот (候城 Hou cheng) нэртэй байсан гэдэг. Жинь улсын үеэс Шэньжөү (瀋州 Shenzhou), Юань улсын үеэс Шэньян лү (瀋陽路 Shengyang lu), Мингийн үед Шэньян жунвэй (瀋陽中衛 Shenyang zhongwei) болсон. 1625 онд Нурхачи энэ хотыг эзэлж аваад, нийслэлээ болгож, нэрийг манж дуудлагаар нь Симиань хот (ма. Simiyan hoton) гэв. 1634 онд “Мүгдэн” хэмээх хөгжих дэгжих гэсэн утгатай манж нэрээр нэрлэсэн. 1644 оноос Дайчин улс Бээжинд төвлөснөөр, улсын нийслэл байхаа больсон боловч эзэнт улсын анхны нийслэл, хаадын төрөн гарсан өргөө болохын хувиар чухал үүрэгтэй байсаар ирсэн. Тиймээс, хаадын бунхан, хааны гэр бүлийн эрдэнэс зэрэг нь энд хадгалагддаг.

хэсгээр буюу одоогийн Хар мөрөн⁶, Нон мөрний зүүн,⁷ Оросын Харбин орчмоор болон Сүнгари голын салбаруудаар, зүүн талаараа амуу будаа тариалж, Монголын тал нутагтай хиллэсэн баруун хэсгээрээ нүүдэллэн аж төрж байв. Жүрчиний энэ бүсэд монгол соёл хүчтэй нөлөөлсөн гэдэг. *Жяньжөү жүрчин* болбоос, Хайши жүрчиний зүүн талаар, Мүдан голын⁸ дагуу, Ялү,⁹ Ляо¹⁰ голын сав, Урт цагаан уул¹¹ орчмоор Мин улсын хил хязгаар Ляодунтай ойролцоо нутаглаж байв. *Жяньжөү жүрчин* нар Сүнгари голын хөндийн дунд хэсгээс гаралтай, Хурха гол болон Нингүтагаар дамжин Урт цагаан уул руу нүүж, өвөг дээдсийнхээ эзэмшиж байсан Хятадын сав газар дахь хилийн нутгаа дахин олж авсан гэдэг (Michael 1965: 39, з. 1). *Жяньжөү* нэрийг О. Латтимор *Жиний овог* буюу *Жиньзү*-ийн гажуудсан хэлбэр байж магадгүй гэж үзсэн (Lattimore 1951: 116, n.29). Нэмж хэлэхэд, Горский Нурхачийг Жинь улсын хунтайжийн арван үеийн шууд хойчис гэсэн сонирхолтой таамаглал бичсэн буй (Gorski 1858: 347/83-385). Хайши жүрчин, Жяньжөү жүрчин хоёул Мин улсад алба барьж, жил бүр хааны ордонд очиж агт морь барьдаг байсан. *Зэрлэг жүрчин* болбоос, Хайши жүрчиний хойд талаар, Их Хянганы уулсын баруун хэсгээс Уссури мөрөн,¹² Хар мөрний доод бие хүртэлх Манжуурын хамгийн хойд хэсгээр нутаглаж, ан гөрөө, загас агнуураар дагнахын зэрэгцээ гахай үржүүлж, нүүдлийн газар тариалан эрхэлж байлаа. Тэдэнд Монголын нөлөө нэлээд туссан байв (Зураг 1).

Таван зууны тэртээ өвөг дээдэс нь Алтан улсыг байгуулж асан хэмээх түүхтэйгээр, дөрвөн зуугаад жил бүдгэрсэн жүрчидийн хойчсыг Зүүн хойд Азиас эрх мэдлийн салхи дэгдээнэ гэж, тэр нь гурван зуугаад жил Зүүн болон Өвөр Азийг эрхшээнэ гэдгийг хэн төсөөлөх билээ.¹³ Гэвч, тэд улс байгуулсан түүхээ дахин сэргээсэн юм. Жяньжөүгийн ноён *Айсин гуоро* овогт Нурхачи (1559-1626)¹⁴ жүрчиний олон аймгийг нэгтгэн 1616 онд Хэтү ала (ма. Hetu ala, хя. 赫圖阿拉城)¹⁵ хэмээх нутагт хаан сууж, өвөг дээдсээ үлгэрлэн дахин *Алтан улс* (ма. Aisin gurun, хя. 金 Jin, 1616-1636) байгуулсан билээ. Дашрамд дурдахад, манж сурвалжуудад зөвхөн Алтан улс (ма. aisin gurun) гэж тохиолддог боловч түүхчид судалгаандаа өмнөх Алтан улсаас нь ялгахын тулд *Хойд Алтан Улс* (Later Jin) хэмээн бичдэг.

⁶ *Хар мөрөн* (Амур мөрөн, ма. Sahaliyan ula, үгч. Хар мөрөн; хя. 黑龙江 Heilongjiang) бол Оросын алс дорнод болон Зүүн хойд Хятадын хил болдог 2824 км урттай, дэлхийн арав дахь урт мөрөн юм.

⁷ *Нон мөрөн* (ма. non ula, хя. 嫩江 nenjiang) Хармөрөн мужийн хойд хэсэг, Өвөр Монголын зүүн хойд хэсгээр урсдаг 1370 км урттай, Сунхуа мөрний хамгийн урт цутгал юм.

⁸ *Мүдан гол* (ма. Mudan ula, хя. 牡丹 Mudan) нь Сүнгари голын баруун цутгалан бөгөөд одоогийн БНХАУ-ын Хармөрөн мужид хамаарна. Эрт үед *Хурха* (хя. 瑚爾哈 Huerha) гэдэг байжээ.

⁹ Ялү (ма. yalu, со. Amrok/amnok) гол нь Түмэн гол болон Урт Цагаан уулын зарим хэсгийн хамтаар Хойд Солонгос, Хятадын хил болдог.

¹⁰ Ляо (хя. 辽河) гол бол Зүүн хойд Хятадын өмнөд дэх хамгийн том гол учир энэ бүс нутагт эх гол хэмээн нэрлэдэг. Хятадын гол мөрний долоон гол тогтолцооны нэг нь болдог, 1,345 км урт.

¹¹ *Урт цагаан уул* (ма. yolmin sanggiyan alin, со. раекту, хя. 長白山/长白山 Changbaishan) нь Зүүн хойд Хятад, Солонгосын хойгийн хил дээр оршдог, манж нарын уугал нутаг. Манж нар угсаа гарлын домгоо эндээс эхлүүлдэг.

¹² *Уссури* (ма. usuri ula, хя. 乌苏里江 wusuli) мөрөн 897 км орчим урттай, Оросын Хабаровск, Приморский край, Зүүн хойд Хятадын зүүн хэсгээр урсдаг.

¹³ *Өвөр Ази* (Inner Asia) гэж баруун талаараа Урал голоос Каспийн тэнгис, зүүн талаараа Манжуураас зүүнш Алтай язгуурын Монгол, Түрэг, Манж-Түнгүс, Урал угсааны Фин-Угри, Самой нарын газар нутгийг нэрлэдэг. Уг нэр томъёо нь *Төв Ази* (Central Asia) хэмээхийг орлон англи хэлнээ нэвтэрсэн ба үүнд О. Латтимор, Д. Сайнор нарын зүтгэл их үүрэгтэй. Төв Азийг оросоор *Центральная Азия* хэмээх бөгөөд *Средняя Азия* буюу Дундад Азиас тусдаа, ангид ухагдахуун. Харин франц хэлнээ *Asie Central* гэдэгт Төв Ази, Өвөр Ази хоёул багтах ба *Haute Asie* хэмээх нэрээр Өвөр Азийн зүүн хэсгийг хэлнэ. Германд, оросын адил *Mittelasiien* гэдэг нь Дундад Ази, *Zentralasiien* гэдэг нь Төв Ази болно. Энэхүү нэр томъёоны талаар Lattimore 1951; Bregel 1996 зэрэг бүтээлийг үзнэ үү.

¹⁴ Зарим бүтээлд түүний өвөг дээдэс нь Юань улсын үед аймгийн түрүү байсан Мөнх төмөр гэдэг. Мөнх төмөр (х. 1405-33) Зүүн Жяньжөү харуулын анхны удирдагч байжээ (Hummel ed. 1964: 594-599).

¹⁵ Нурхачийн өвөг, Жүрчин аймгийн ноён Гиочангагийн нутаг. 1616-1622 онд Алтан улсын нийслэл байсан. 1634 онд нэрийг нь *Шинжин* (興京 Xingjing) болгон өөрчилжээ. БНХАУ-ын Ляонин мужийн Шиньбинь тойрогт Сүзы гол дагуу оршдог.

Нурхачийн наймдугаар хүү Хунтайж (1592-1643) 1626 онд эцгийнхээ орыг залгаж, Алтан улсын хоёр дахь хаан болон тулгар төрийг өвлөөд, *Дусал бинтгүй үсгийн данс*¹⁶-нд тэмдэглэсэнээр (1969, Vol.IX: 4509), жүрчин үндэстнийхээ уг нэрийг 1635 онд *манж* (ма. manju, хя. 滿洲 manzhou) хэмээн халж, 1636 онд Алтан улсаа *Дайчин улс* (ма. daijing gurun, хя. 大清 daqing)¹⁷ болгон сольж, угсаа гарлын домгоо бичиж,¹⁸ улс үндэстнээ “шинээр томьёолсон” юм.

Хунтайжаас эхтэй энэ үйл хэрэг нь “манж ижилсэл” (manchu identity)-ийг бүтээсэн хэмээн олон судалгаа өгүүлдэг. Жишээлбэл, П. Кроссли манж ижилсэл хаант улсын нэгдэл, төвлөрлийн явцад үзэл суртлын үүднээс бүтээгдсэн болохыг (Crossley 1999); М. Эллиот манж ижилслийг хошууны тогтолцоонд хэлээр хэрхэн бүтээснийг, манж гэдэг нэр жүрчиний хошууны тогтолцооны ялгааг арилган нэгдмэл байдлыг тэтгэснийг (Elliot 2001); манжийн төр эзэнт гүрнээ ухамсартайгаар төвхнүүлж, олон үндэстнээ нэгтгэн жолоодоход чухал байсныг (Campbell and Lee 2002, Millward 2004: 98); Сүнь XVII-XVIII зууны дунд үе хүртэл зохиогдсон манж, хятад хэлээрх манжийн угсаа гарлын домгийн дөрвөн хувилбар манж ижилслийн хэрэгсэл, хөгжлийн тусгал болсныг өгүүлсэн (Sun 2016) гэх мэт.

Манж нарын үүх түүхэнд ихээхэн ач холбогдолтой, дээр дурдсан *жүрчин*, *зэрлэг жүрчин*, *Жяньжөү*, *Хунтайж*, *манж*, *Дайчин* гэсэн нэрсийн утгын талаарх санал таамаглалыг танилцуулсан зүйл манайд цөөвтөр байгаагийн дээр, заримдаа монголоор уг нэрээс нь зөрүү бичих явдал тохиолддог учир, энэхүү өгүүлэлд өнөөдрийг хүртэл олон таамаглал дагуулсаар ирсэн эдгээрийн нэрийн уг утга, бичлэгийг түүхэн сурвалж бичгүүд дэх холбогдох мэдээ баримт сэлт болон судлаачдын бүтээлийг харьцуулан авч үзье.



Зураг 1. Манжуур болон Зүүн Монголын газрын зураг. (Di Cosmo 2016: 113).

¹⁶ Уг нэр нь ма. *Ejehe dangse*, хя. 舊滿洲檔 Jiu Manzhou Dang бөгөөд монголчилбол *Ойлого данс* гэдэг. *Дусал бинтгүй үсгийн данс* (*Tongki fuq aqū hergen-i dangse*) бол Тэнгэрийн тэтгэсний үед ялгаж өгсөн нэр болно. Хойшид ДБУД гэж товчилно.

¹⁷ Дайчин улсыг Цагаан хэрэм давж, Бээжинд орсон цагаар нь ихэвчлэн 1644-1912 онд оршин тогтносон хэмээдэг.

¹⁸ Манжийн угсаа гарлын талаарх Айсин гиоро овогт Бүкури Ёншоноос эхтэй домог 1635, 1636 оноос л Дайчин улсын сурвалжуудад тохиолдож эхэлдэг. Энэхүү домгийн манж болон хятад хэлээрх дөрвөн гол хувилбар бий нь Дээд эрдэмтийн хувилбар (1635), Эсэр засагчийн хувилбар, Энх-Амгалангийн хувилбар, Тэнгэрийн тэтгэсний хувилбар болно. Эдгээр домгийн хувилбаруудын харьцуулсан судалгааны тухайд Sun 2016 -ийг үзнэ үү.

Судалгааны хэсэг

Хунтайж

1626 онд эцгийнхээ орыг залгасан Нурхачийн хүү Хунтайж тулгар төрийг өвлөн аваад, өргөжүүлэн мандуулснаараа түүхэнд тод үлдсэн юм. Түүний цол нь *Богд сэцэн хаан* (ма. *ᠶᠣᠰᠢᠨ ᠠᠨᠴᠣ ᠬᠡᠭᠠᠯᠢᠶ᠋ᠠᠰᠤᠨ ᠡᠨᠳᠦᠷᠢᠭᠭᠡ ᠬᠠᠨ*, мо. өршөөл агуу найрамдуу богд хан), сүмийн нэр нь *Тайзун* (太宗 taizong), нэхэн өргөмжилсөн нэр нь *Вэнь хуанди* (文皇帝 wen huangdi, ма. *ᠰᠤ ᠬᠡᠭᠠᠨᠳᠢ*). Тэр бээр хоёр оны цолтой байсны эхнийх нь *Тэнгэрийн сүлдэт* (ма. *abqai sure*, хя. 天聰 tiancong, 1627-1636), удаах нь *Дээд эрдэмт* (ма. *wesihun erdemungge*, хя. 崇德 chongde, 1636-1643).

Уг нэрийнх нь тухайд Абахай, эсвэл Хунтайж гэсэн хоёр хувилбарыг хэлэлцэж иржээ. А. Хюммелийн эмхэтгэсэн намтрын толиос (1964) авхуулаад өрнөдийн хэлээрх XX зууны эхэн үеийн олон бүтээлд түүний нэрийг *Абахай* гэж бичиж байсан ба монгол хэлээрх зарим бүтээлд одоо ч энэ нэрээр үзэгддэг. Группер монгол хэлний *abagai* гэдэг үгээс үүссэн байж магадгүй (1984: 69) гэсэн байдаг боловч Стари оросын эрдэмтэн Горскийн хийсэн алдаа, Абахай гэдэг нь Хунтайжийн авсан эхний оны цол болох ма. *abqai sure* (тэнгэрийн сүлдэт) гэдэг манж үгийг ташаарсан бололтой гэсэн нь үнэмшилтэй тайлбар болно (Stary 1984: 296-299). Үүний дээр, манж сурвалжуудад түүнийг гагцхүү Хунтайж гэдэг нэрээр тэмдэглэгдсэнийг үндэслэн, Абахай гэдэг нэрийг хэрэглэхээс нэгэнт зайлсхийх болжээ.

Харин *Хунтайж* хэмээх нь нэр үү, цол уу гэдэг дээр маргаантай байсаар байна. Бичлэгийн тухайд, манжаар *hong taiji*, хятад, солонгос сурвалжид 洪台極 (*hong taiji*) (Crossley 1999: 164-165) гэж бичиж байв. Гарлын тухайд, монгол хэлнээс ормол гэсэн санал нийтлэг (Rawski 1998:50, Pang and Stary 1998: 13, Elliot 2001: 397, з.71). Тэмдэглэхэд, хятад хэлний 皇太子 (*huangtaizi*) гэдэг үг монгол хэлнээ эрт цагт орж хунтайж гэсэн монголжсон дуудлагатай болсон бөгөөд түүхийн зарим үед хаан ор залгамжлагчийн нэрлэж байв. Хааны нэрийг цээрлэдэг ёсны дагуу, хожмын хянан засварласан манж сурвалжуудад түүнийг хэргэм зэргээр нь *Дөрөвдүгээр бэйл* (ма. *duici beile*) хэмээн бичиж байсан (Crossley 1999: 164) боловч 1996 онд олдсон баримтад түүнийг “Хунтайж” хэмээн бичсэн байдаг, Нурхачи залгамжлагчаа зарлан тунхаглаагүй байсан зэрэгт үндэслэн Т. Пан, Ж. Стари, М. Эллиот зэрэг эрдэмтэд Хунтайж гэдэг цол бус, өөрийнх нь уг нэр юм гэж үздэг (Pang and Stary 1998: 13, Elliot 2001: 397, з. 71).

Жүрчин

Жүрчин (анг. Jurchens) хийгээд түүнд олон тооны -д дагавар залгасан *жүрчид* хэмээх нэрсийг монгол хэлээр *жүрчин*, *жүрчид*, *зүрчин*, *зөрчин*, *зөрчид*, *зүрчид* гэх зэргээр харилцан адилгүй хэлж бичиж иржээ. Эдгээрийн зөв хувилбарыг тогтоохын тулд, хятан, жүрчин, манж хэлээрх сурвалжид хэрхэн бичиж ирсэн түүх хийгээд судлаачдын таамаглалыг харьцуулан мөшгөж үзье.

Хятад сурвалжид *Жүрчин* гэдэг нэр Тан Улсын үеийн (618-907) буюу VII зууны эхний хагаст хамаарах хятад сурвалжид тохиолддог (Gorelova 2002: 10). Хятадаар, 女直 (*nü zhi*), 女眞 (*nü zhen*) гэсэн хоёр ханзаар тэмдэглэж иржээ. Тэмдэглэхэд, 女 (*nü*) гэдгийн ус гэсэн утгатай түлхүүр ханз агуулсан хувилбарыг (汝 *ju*) *жү* гэж уншдаг.¹⁹ Зарим эрдэмтэн ийнхүү хоёр ханзаар тэмдэглэсний учрыг 926 онд Хятан (契丹 Qidan) Бохайг мөхөөснөөр, тэдний бүрэлдэхүүнд асан жүрчин нар Хятаны Ляо улсын (辽 Liao, 907-1125) эрхшээлд орсноос хойших цаг үед, Хятан улсын хааны нэрийг цээрлэснээс үүдсэн хэмээн тайлбарласан нь бий. Тодруулбал, Хятаны Шинзун хааны (興宗 xingzong, 1031-1055) хятад нэр болох Зунжэнь (宗眞 Zongzhen) гэдэг нэрийг хэрэглэхээс цээрлэн, 眞 (*zhen*) үсгийг өөрчлөн 直 (*zhi*) болгон өөрчилснөөр, 女直 (*nü zhi*) гэх болсон гэдэг (Serruys 1955: I, n.1, 28-41).

Тэгвэл, Үлхичүн, Жинь Шы нар хятад бус буюу хятан, жүрчин сурвалжууд дахь жүрчин гэдэг нэрийг мөшгөөд, цээрлэсэн учир шалтгаанаас бус, харин жүрчин хэлний нутгийн аялгуунуудын ялгаатай холбоотой байж болохыг гаргаж тавьжээ. Тэдний судалгааны дагуу,

¹⁹ Тиймээс ч, “Юань улсын судар”-т жүрчинийг *усны татар* гэсэн байх ба зарим овгийг нь одоо ч *загасчин татар* гэнэ. Хожмын сурвалж Саган Сэцэний “Эрдэнийн товч”-д Нурхачи *усны гурван жүрчидийг* тойндоо оруулсан гэсэн буй (2006: 175).

хятад бус сурвалжид *жүрчин* гэдэг нэр анх Хятаны Ляо улсын Даозун хааны (х. 1055-1101) эмгэнэлийн бичигт хятан бага бичгээр *'julishen'* гэсэн дуудлагатайгаар тэмдэглэгдсэн байдаг бол Мин Улсын үеийн жүрчин бичгийн дурсгалд *jushen, jushe* хоёул тохиолдоно.²⁰ Жишээ нь, 1413 оны Юннинси (Yongningsi)-ийн бичээсэнд жүрчин бичгээр *'jushe'* гэсэн дуудлагатай бичигдсэн бол Мин Улсын Орчуулгын хэлтсээс (Siyiguan, Bureau of Translations) гаргасан *Жүрчин хэлний толь бичиг* (Nüzhen yiyu)-т *'jushen'* гэсэн дуудлагатай буй. Мин Улсын үед *Орчуулгын хэлтэс* (Siyiguan) болон *Хэлмэрчдийн хэлтэс* (Huitongguan, Bureau of Interpreters)-ээс хоёр зүйлийн *Жүрчин хэлний толь бичиг* эрхлэн гаргажээ. Орчуулгын хэлтэс жүрчин хэлний жяньжөүгийн аялгуунаа, *Хэлмэрчдийн хэлтэс* хайшигийн аялгуунд түшиглэсэн байх боломжтой учир, жүрчин гэдэг нэр зарим аялгуунд *жүшэнь*, заримд нь *жүшы* хувилбартай байсан гэж үзэх үндэстэй (Ulhicun нар 2007: 136-137).

Манж хэл, бичгээр жүрчинийг ма. *jušen* гэнэ. *Манж* (ма. manju), *жүрчин* (ма. jušen) гэдэг хоёр нэрийг Нурхачийн үеэс авхуулаад Хунтайж хааны Дээд эрдэмтийн үе хүртэл хоёул хэрэглэгдэж байв. Манжийн угсаа гарлын домгийн 1635 оны хоёрдугаар хагаст Ордны түүх бичлэгийн хүрээлэнгийн дансанд тэмдэглэгдсэн (內國史院檔) Дээд эрдэмтийн хувилбарт гурван овгийн хүмүүс тэмцэлдэж бүхүйд Тэнгэрийн хаан нэгэн хувилгааныг *Жүрчин улсад* (ма. jušen gurun) илгээхээр шийдэв хэмээж буй (Sun 2017: 95). ДБҮД-нд тэмдэглэснээр, 1635 оны билгийн 10 сарын 13-нд:


“Тэр өдөр хаан өгүүлрүүн: Манай улсын нэр угаас Манж, Хада, Ехэ, Хойфа болой. Түүнийг ухахгүй хүн Жүрчин хэмээмүй. Жүрчин хэмээх нь Шивэй. Чуу мэргэний удам болой. Тэр бидэнд ямар хамаа. Үүнээс урагш [хойш Э. М] аливаа хүн манай улсыг уг Манж хэмээх нэрийг дууд. Жүрчин хэмээн дуудваас ял”

хэмээн Хунтайж *'jušen'* хэмээх нэрийг *'manju'* болгон өөрчилж, дахин хэрэглэхийг хоригложээ (JMD 1969: 4508). Энд Хунтайж жүрчин гэдэг нэрээс татгалзсан шалтгаанаа Монголын Жүрчидийн Чуу мэргэнтэй холбон өгүүлсэн бөгөөд энэ талаар хойно манж гэдэг үгийн тухайд дахин хэлэлцье. Харин судлаачдын саналыг харьцуулан дурдвал, Линь Сүнь жүрчин гэдэг нэр Хань хятадуудын дунд сөрөг үнэлэмжтэй байсан тул Хятадыг байлдан дагуулахыг эрмэлзэж байсан Хунтайжийн хувьд энэ нэрээ цаашид ашиглах зохисгүй болох нь ойлгомжтой гэжээ (2016). Энд Линь Сүнь магадгүй жүрчин гэдэг үгийн *албат харц* гэсэн утгыг харгалзсан бололтой. Манж хэлний эрт эдүгээгийн толь бичгүүдэд ма. *jushen* гэдэг үгийн утгыг *албат, харц* гэсэн байдаг (*Таван хэлний толь* 1957: 1147, 2881; Lubsangjab, Siraküü 1968: 491). Харин судлаачид энэ нэр жүрчин нарыг нийтэд нь нэрлэхийн зэрэгцээ бас язгууртан бус хүмүүсийг заадаг (Di Cosmo 2016: 116) гэсэн байдаг бол Үлхичүн нар ДБҮД-ны 1619 оны тэмдэглэлд тэр жил Алтан улс *бүх жүрчин хэлтэн улсыг* дагуулан авав гэсэн мэдээнд үндэслэн, тухайн үеийн жүрчин хэлтэн Хятадын зүүн этгээдээс Япон тэнгис, Солонгосын хойд нутаг, Монголын өмнөд хэсэг хүртэл өргөн уудам нутагт тархсан байсан хийгээд жүрчин хэл гэдэг нь түнгүсүүдийн бүхий л хэл аялгууг багтаан агуулдаг учир жүрчин гэдэгт зөвхөн манж нарын өвөг дээдсийг төдийгүй бүхий л манж-түнгүс угсаатныг нийтэд нь зааж байсан бололтой гэсэн харгалзахгүй үлдээхийн аргагүй тайлбар хийжээ (2007: 136). Эндээс үзвэл, миний бодлоор, Хунтайж бээр Линь Сүний анзаарсан сөрөг үнэлэмжийг бодолцсон гэхээсээ, тухайн цагийнхаа нийт түнгүс угсаатны дундаас өөрсдийгөө “манж” хэмээн онцлон ялгаж нэрлэсэн бололтой. Ийм утгаар авч үзвэл, судлаачдын онцлон тэмдэглэдэг шигээр, жишээлбэл, М. Эллиот манж гэдэг шинэ нэр томьёо нь шинээр гарч ирж буй жүрчин нарын өвөрмөц байдлыг нэг нэрээр, нэгдмэл байдлаар харуулахад Хунтайжид тусалсан гэж мэтгэсэн байдагчлан (2001: 39) манж ижилслийг амжилттай бүтээсэн үр дүнд хүргэж чадах юм.

²⁰ Үүнчлэн, хятан бага бичгийн дурсгалд овог аймгийн нэрийн төгсгөлийн “н” гийгүүлэгч заримдаа бичигдэж, заримдаа гээгдэх тохиолдол цөөнгүй байдаг аж (Ulhicun нар 2007: 137).

Зэрлэг жүрчин

Өмнө дурдсанчлан, Мин улсын үеийн жүрчинийн нэгэн гол хэсгийг нэрлэсэн *Ежинь* (хя. 野人 Yejin) хэмээх нэрийн утгын тухайд, Эсэр засагчийн 3-р онд (1646) зарлигаар зохиосон “*Алтан улсын судар*”-ын тэргүүн дэвтэрт өгүүлснээр, “Хятан улсад орж өмнөдөд суусныг нь болсон нюй жы (ма. *urehe nioi zhi*), Хятан ороогүй хойдод суусныг нь зэрлэг нюй жы (ма. *eshun nioi zhi*) улс хэмээв” гэсэн байдаг (Я. Шаарийбуу 1999: 33). Манжаар *urehe* нь болсон, боловсорсон, *eshun* нь түүхий, зэрлэг гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл, Алтан улсын судрын дээр эш татсан хэсэгт үндэслэвэл, Хятаны өнцгөөс, тэднийг дагаар орсон нь болсон, соёлтой боловсон, харин дагаар ороогүй нь зэрлэг түүхий, соёлгүй боловсон бус болно. Манжийн *eshun nioi zhi* гэдгийн хятад нэр болох *yejen* ч, Чусонь улсын үед (1392-1910) солонгосчууд тэднийг ‘barbarian’ гэж үзэж нэрлэж байсан со. *yain* (Jongtae 2016: 146), хожмын англи нэр *wild Jurchens* ч бүгд “зэрлэг” гэсэн утгатай. Энэхүү нэр нь томоохон соёл иргэншлийн төв болсон юм уу хүчирхэгжсэн улсуудын дунд түгээмэл тохиолддог, өөрсдийгөө төв болгон, бусдыг бүдүүлэгт тооцох үзэлтэй холбоотой болно.²¹



Зураг 2. Хааны бичсэн таван зүйлийн үсэг хавсарсан толь бичиг дэх *juŋen* гэдэг үгийн тайлбар (1957: 1147, 2881).

²¹ Ийм үзэл өрнө дахинд бүдүүлгүүд (*barbarian*) гэдэг нэр томъёогоор илэрдэг. Анхандаа, грек хэлний *bárbaros* хэмээх юу хэлж байгаа нь мэдэгдэхгүй буюу грек хэл мэддэггүй гэсэн утгатай энэ үгээр ХТӨ V зуунд грекчүүд персчүүдийг хэлж байжээ. Хожим уг нэрийг Грек, Ром зэрэг өрнийн соёлын төв болсон улсууд өөрсдөөсөө өөр хэл соёлтныг нэрлэхдээ авч хэрэглэсэн нь яваандаа *иргэнийггүй* - бүдүүлэг гэж үзсэн хүмүүсээ нэрлэх нэр томъёо болон хэвшсэн аж. Дорно дахинд, Хань хятадууд нүүдэлчдийг ийнхүү үздэг хятад төвт хандлага эртнээс байж ирсэн билээ.

Манж

Дээр дурдсан ДБУД-ны баримтыг эргэн санавал, шууд утгаар Хунтайжийн хувьд үндэс угсааг чухалчилсан бөгөөд жүрчин гэдэг нь монгол гарал угсаатай хамаатай учраас татгалзсан ба манж гэдэг нь Хада, Ехэ, Хойфа нарын зэргээр түнгүс угсааныхны хэрэглэж ирсэн нэр гэж тайлбарласан байгаа. Тэгвэл, хэдий зарим нь манж гэдэг нэрийг Хунтайжийн зохион бүтээсэн зүйл гэдэг боловч, бүр өмнө “Дусал бинтгүй үсгийн данс”-нд 1613 онд холбогдох газар тохиолддог аж (JMD 1969 I:81). Рот Ли 1628 оноос хааяа хэрэглэгдэж эхэлснийг тэмдэглэсэн буй (Roth Li 1975: 10). Өөрөөр хэлбэл, манж гэдэг нэр урьд өмнө нийтлэг дурдаагүй ч гэсэн байсаар ирсэн нэр гэсэн утга агуулагдаж байна.

Тэгэхээр, энэ нэрийн утгыг ямар боловч түнгүс соёл, уламжлал дундаас хайх нь илүү магадлалтай байх биз ээ.

Энэ нэрийн утгын талаарх түүх бичлэг, олон санал таамаглалыг хураангуйлан танилцуулбал, Дайчин улсын ордныхны 滿洲源流考 (Manzhou yuanliu kao)-ийн эхний бүлэгт манжү нь Манзушири бурханы нэрээс гаралтай (Agüi et al. 1783, 1988). Үүнийг өөрсдийнх нь бичиж үлдээсэн албан ёсны тайлбар гэж хэлж болох юм. Энэ тайлбарыг Фань Вэнь Лань бээр ман нь Манзуширийн эхний үе, жү нь Жяньжөүгийн жү гэж арай дэлгэрүүлсэн (Huang 1990: 276). Харьцуулахад, олон судлаач манж гэдэг үгийг ийнхүү бурхны нэртэй холбосныг үнэмшилтэй бус, зориудаар зохиосон гэдэг. Жишээ нь, Ж. Норман урьд өмнө нь Буддын шашны бурхны нэрээр угсаа үндсээ нэрлэж байсан түүх Монголчууд болон Жүрчин нарын дунд үгүй хэмээх үгүйсгэх үндэслэлийг гаргасан буй (2003: 484). Гэтэл, 1777 онд Тэнгэрийн тэтгэсэн хаан гэнэт дээрх тайлбараас татгалзаж, эртний сүшэнь хүмүүсийн нэрээс гаралтай болгон өөрчлөв. Нэмж хэлэхэд, жүрчин нарын уг гарлыг Оросын алс дорнод, Манжуурын бүс нутгаар нутаглаж асан өвөг түнгүсийн сүшэнь (sushen), илоу (yilou), вүжи (wuji), мохэ (mohe) овгуудтай харилцан адилгүйгээр холбож үздэг (Crossley 1997: 215).

Зарим түүхэн сурвалж энэ талаар арай өөр зүйл тэмдэглэжээ. Тухайлбал, 1711 онд Хятадаар явсан Солонгос элч түшмэл Ким Кён Мум нэгэн манж бошгоос, ман нь арван мянган жүрчин дайчин, жү нь үргэлжид мандах гэж дуулснаа тэмдэглэж үлдээсэн нь өөр ямар ч сурвалжид байдаггүй боловч, жүрчин уламжлалтай холбогдсоноороо сонин. Хятадын түүхэнд жүрчиний толгойлогч хятадын цэргүүдэд хөөгдөж байхдаа гахайн дунд нуугдсан бөгөөд цэргүүд ман жү (хя. 满猪 man zhu, мо. бүгд гахай) гэж хашхираад эрлээ зогсоосноор, толгойлогч нь амь гараад, ард түмнээ Манж гэж нэрлэсэн гэдэг. Энэ нь нэлээд домгийн шинжтэй.

Түүхэн хүн, цолтой холбон тайлбар гэвэл, Э. Хауэр Жяньжөүгийн хүчирхэг ноён Ли Манжүгийн нэрээс гаралтай гэжээ (1926: 592). Мэн Сэнь, Шяо И Шань нар их удирдагч хэмээх жүрчин цолоос гаралтай гэснийг В. Горский дэмжсэн (Lattimore 1951: 116. з. 28).

Хэлний талаас нь авч үзэх хандлага бий. Широкогоорофф нэгдсэн мужууд гэж үзсэн боловч, баримтаар нотолсон зүйлгүй (1924: 9-10). Тэр бээр бас 1777 оны хааны зарлигт дурдсан манжү (хя. 满珠 manzhu) гэдэг үгийг анхаараад, сувдаар баян гэсэн утгатай, сувд гэсэн утгатай жү (хя. 珠 zhu) нь жоу (洲 zhou)-аар солигдсон гэсэн байдаг (1924: 160). Ичимура Санжиро mangga (мо. баатар)-тай холбожээ (1939: 492). Manju, mangga хоёр хэлний талаас хэрхэн тохирох нь жаахан эргэлзээтэй. Айсин гиоро Үлхичүн монгол хэлний баатар гэдэгтэй холбосон байдаг (Wilkinson 2000: 728-729). Ж. Стари түнгүс үг гэж үзээд, ман нь хүчтэй, жү нь байх болтугай гэсэн утгатай дагавар гэдэг санал дэвшүүлэв (1990: 113-115).

Газар усны нэрээс үүтгэх нэлээд үндэслэлтэй гэмээр саналууд бас бий. Жишээлбэл, Хуан Чанжянь Жяньжөү жүрчиний төвлөсөн газрын нэрээс үүтгэсэн байдаг. Бас В. И. Цинциус түнгүс хэлний том гол гэсэн утгатай *mangu гэдэг үг байж болох юм гэсэн (1949) ба үдэхэ (maŋtu ~ mangu), улчи (mangu), орох (maangu), хэжэн (mamŋu) зэрэг түнгүс хэл аялгуунд бүгд Амур мөрөн, Сунгари мөрөн, Уссури мөрөн зэргийн тухайд хэрэглэх том гол гэсэн утгатай аж (Цинциус нар 1975-77: 1.525-26). Ж. Норман энэ саналыг олон талаас нь батжуулан тайлбарлахдаа, нэгд, түнгүс хэлний “ng” давхар гийгүүлэгч манж хэлэнд -ŋj-

болдог тогтлын дагуу²² *mangu гэдгээс manju үүссэн байх авиан зүйн боломжийг өгүүлээд, хоёрт, тэдний өвөг Алтан Улсыг байгуулсан Ваньянь аймаг жүрчин хэлний алт гэсэн утгатай анчун гэдэг үгээр нэрлэгдсэн Анчуху (ancuhu) голоор нутаглаж байсан ба улсаа Алтан улс хэмээн нэрлэсэн хийгээд Ула (ма. Ula, том гол), Усури (ма. Usuri, Уссури голын нэр), Мүрэн (мо. мөрөн), Хүнэхэ (Ляодунгийн Хүнь голын нэр), Ехэ (Ехэ голын нэр) гэхчлэн гол мөрнөөр овог аймгаа нэрлэх явдал түнгүсийн дунд нийтлэг байсан, гуравд, Алтайн болон Төв Азийн ард түмний дунд Атилла (itil, idil буюу Ижил мөрний эртний нэр) Чингис хаан (эрт. тү. teŋiz буюу далай), Далай лам зэргээр их усыг нэр цолд бэлгэдэн хэрэглэдэг уламжлал, дөрөвд, манж гэдэг нэрийг тэмдэглэсэн хоёр ханзанд (滿洲) хоёуланд нь ус гэдэг ханз агуулагдаж байгаа зэрэг үндэслэлийг өгүүлжээ (2003: 484).

Нэмж хэлэхэд, Дайчин улсын эхэн үед манж нарыг дотор нь Манж жиү/фү (ма. 舊/佛chiu/fu), Манж ичэ (ма. iše, мо. шинэ, хя. 伊徹yi che) гэсэн хоёр нэрээр хуваан ялгаж байв. Хуучин Манж нь 1636 оноос өмнө Нурхачи болон Хунтайж нарт нэгдэгсдийг хэлэх ба тэд Дайчин улсын мандлын үндэс болсон хошууны хүчний цөм болж байсан юм. Шинэ манж нь Солон, Орчон, Дахуур гэх мэт алслагдсан зэрлэг жүрчид байсан бөгөөд манжийн хошуунд хожим нэгдсэн тул ийн нэрлэгджээ. Тэдний ихэнхийг 1636-43 онд Хунтайж, цөөн заримыг бүр сүүлд Энх-Амгалангийн үед харьяандаа оруулжээ. Зарим судалгаа Шинэ манж нарыг элсүүлсэн цаг хугацааг Найралтын төвийн үед хэмээн хойшлуулсан нь ч бий (Lee 1970: 33-34).

Дайчин

Энэхүү өгүүлэлд авч үзэж буй учир нь тодгүй сүүлийн нэр бол *Дайчин* юм. Энэ нэрийг монгол хэлээрх бүтээлд Дайчин улс, Чин улс, Чин гүрэн, Манж Чин улс, Их Чин улс гэхчлэн янз бүрээр бичиж иржээ. Ийнхүү зөрөөтэй бичлэгийн улмаас, утга, бичлэгийн талаар нягталж үзвээс,

Бичлэгийн хувьд, ма. Daičing, хя. 大清 Da Qing гэдэг. Утгын талаас, эртхэн үеийн саналд, *Дайчин* гэдгийг тэмдэглэсэн ханзных нь утгатай холбож үзсэн зүйл бий. Жишээ нь, Ж. Росс улсын нэрийг тэмдэглэсэн хоёр ханзаар нь тусгаарлаж, эхний *дай* (大 da) гэдгийг хятад хэлний *их* гэсэн утгатай үг гээд, улмаар *Чин* (清 qing) болон *Манж* (滿洲manzhou) гэдэг нэрс хоёул ус гэсэн түлхүүр ханз агуулж буй учир *усны тунгалаг* гэсэн утгатай бөгөөд эргэлзээгүй өмнөх Мин улс (明ming) буюу *тод гэрэл* - нарны тунгалгаас улбаалсан гэжээ. Тэр бээр Хятадын угсаа залгамжлах хаант улсуудын нэр бие биеэсээ авсан бололтой гээд, Ляо (遼 Liao) бол “хүчтэй” *Төмөр*, түүнийг Жинь (金Jin) – “өнгөө үл алдах” *Алт* дагасан, дараа нь Юань (元 Yuan) хэмээх *Мөнгө* буюу *Жинхэнэ уг гарч*, Юанийг Мин уламжилсан гэж үзсэн нь (Ross 1973: 515) сонирхолтой юм. Түүний тайлбар нэг хэсэг эрдэмтдэд нөлөөлсөн байдаг.

Гэтэл эсрэгээр, ийнхүү харь нэр усыг ханзаар тэмдэглэхдээ утга харгалздагийг үл таашаах нь ч бий. Мин Дон Гү бээр *Мин*, *Чин* гэдгийн гэгээн тунгалаг гэсэн хятад ханзнуудын утга бараг солиорлын маягтай гэсэн байдаг (Gu 2003: 112-129).

С. Групперийн тайлбар нэлээд хачирхалтай гэж болно. Тэр бээр *дайчин* гэдгийг нэг үгээр сэтгэж, мо. Daičín болон ма. Daičing хоёрын “н” ялгаатай болохыг анхаараад, санскрит хэлний *Махааяана* гэдгийн төвөд орчуулга (тө. dai-chin)-ыг хятадаар *ta-ch'eng* гэж тэмдэглэдгээс санаагаа үүтгэжээ (1989: 69-70). Түүнийхээр, манж нарын байгуулсан улсын нэр *Их хөлгөн* (Great Vehicle) гэдэг нэртэй болж байна. 1636 онд, хэдийгээр баруун хөрш-монголд буддын шашин дэлгэрч байсан, Хорчиноор дамжин нэвтэрч байсан ч удган шүтэх итгэл үнэмшил нь хүчтэй хэвээр байсан. Ялангуяа, улсынхаа нэрийг өгөхдөө бодолцох хэмжээний хүчин зүйл болж чадахгүй биз ээ. Тэд “хуучин манж нар” байсан. Хэрэв олон үндэстнийг нэгтгэн захирч, төрийн бодлогоор харьяатуудынхаа шашин шүтлэгийг хөхүүлж байсан хожмын хаадын үед, XVIII зуунд улсынхаа нэрийг сольсон бол өөр хэрэг. Тийм болохоор, үнэмшихэд бэрхтэй.

²² Жишээлбэл, тавын тоог түнгүс хэлнүүдэд нийтлэг *tunga гэдэг бол манжаар *sunja* гэдэг.

Ж. Стари, М. Эллиот нараас аваад, монгол хэлний дайн байлдаанд гаргуун гэсэн утгатай *дайчин* гэдгээс гаралтай гэдэг санал бий (Stary 1990b: 114, Elliot 2001: 402, з. 118). Хэрэв монголчуудын нөлөө хэдэн зууны турш амьдралын олон талаар ихээхэн туссан байсан цаг үед нь авч үзвэл, монгол хэлний *дайн* гэдэг үгэнд тухайн үйлийг эрхэлж дадсан хүнийг заах *-чин* дагавар залгаж бүтсэн, *дайчин* гэдэг үгтэй холбосон тайлбарыг монгол цус холилдсон, монгол хэл, монгол боловсролыг мэддэг манж нар анхаараагүй гэхийн аргагүй.

Харин улсынхаа нэрийг хятад ханзаар тэмдэглэхдээ “Эдүгээ Дайляо, Алтан, Сүн, Дай Юань энэ дөрвөн улсын төрийг хичээн засаж улсыг мандуулав” хэмээсэнчлэн (JMD 1969: 4270-71) эхний үеийг нь эдгээр улсын адилаар Дай (大) хэмээн оноосон биз ээ.

Судалгааны үр дүн

Манж нарыг тодорхойлж ирсэн дээрх нэрсийн утга хийгээд олон хэлээрх бичлэгийг авч үзсэний үндсэн дээр дараах үр дүнд хүрч байна. Нэгд, Хунтайжийн нэрийг Абахай гэж бичих үндэслэл байхгүй бөгөөд түүний нэр нь нэг талаас тухайн цагийн манж нарт монголын нөлөө хэр их байсныг харуулах нэгэн жишээ гэж хэлж болох юм. Хоёрт, монголоор зүрчин, зөрчин гэж бичих үндэсгүй, харин жүрчин гэж бичиж хэвших нь зүйтэй байна. Гуравд, манж гэдэг нэрийн утга, гарлын талаарх маш олон санал таамаглал хэдийн гарсан бөгөөд цаашид ч ямар нэгэн шинэ санаа дэвшүүлсээр байхыг үгүйсгэх аргагүй юм. Тийм боловч, одоогоор дэвшүүлж хэлэлцсэн тайлбаруудын хүрээнд, хамгийн байж болохуйц нь том гол мөрөн гэсэн утгатай манж -түнгүс үг мэт санагдаж байна. Дөрөвд, Дайчин гэдэг нэрийн тухайд, бусад тайлбартай харьцуулахад мөн л монгол үгээс гаралтай байх боломж нэлээд үндэслэлтэй. Бичлэгийн хувьд, Дай Чин юм уу, Чин зэргээр уг нэрийн хагасыг хэрэглэх нь манж нэрийг бус, хятад ханзаар тэмдэглэсэн нэрийг хэрэглэж байгаа хэрэг. Мөн Монгол Юань улс гэхгүй, Монголын Юань улс гэдэгчлэн, Манж Чин улс гэхгүй Манжийн Дайчин улс болно. Өөрөөр хэлбэл, Хунтайжийн өгсөн буюу албан ёсны Дайчин хэмээх манж нэрийг баримталбал зохих биз ээ.

Дүгнэлт

Эцэст нь хэлэхэд, Хунтайж улс төрийн зорилгоор урьд байсан нэр томьёо, тэдгээрийн утга, өнгө аясыг харгалзан, улс үндэстнээ нийт түнгүс угсаатны дундаас ялгаруулан шинээр томьёолж, зөвхөн жүрчин бус, хятад, монгол бусад үндэстнийг багтаасан улс болох замналыг засаж өгсөн их үйл хэргийн үр дүн болсноороо тус өгүүлэлд авч үзсэн эдгээр нэр үлэмж ач холбогдолтой. Үнэхээр, Пэй Хуангийн тэмдэглэсэнчлэн, Хунтайжаас өөрөөс нь ямар нэгэн аргаар асууж мэддэггүй л юм бол нэрийн утга, нууц хэзээд тайлагдахгүй байж ч магадгүй боловч (1990: 280), бидэнд хийж лавтайяа хийж чадах нэг зүйл бий. Тэр нь утга учрыг нь ойлгосны дагуу, эдгээр нэрсийг манж хэл бичгээрх сурвалжийн баримтад түшиглэн, албан ёсных бичлэгийг монголоор зөв буулган бичих явдал юм.

Abstract

The correct spelling of any name directly depends on its origin and meaning. There are some cases where key names, such as *Manchu*, *Hongtaiji*, *Jurchen* and *Daiching* related to the history of the Manchus are incorrectly written in Mongolian. Therefore, it is essential to introduce research on the meaning of these names. According to an *International Bibliography of Manchu Studies*, by 1990, 17 articles were published on the origin and meaning of the name “Manchu” (Stary 1990a: 870). The number shows us how serious the issue is. Pei Huang (1990: 280) claims that tracing the real meaning of the name Manchu is fruitless. However, it does not mean that all related studies are worthless. On the basis of these studies, it is possible to support some arguments, and also, one can suggest the correct spelling of these names in the Mongolian language. This article aims to suggest the Mongolian spelling of the above mentioned names based on their available Manchu, Chinese, Jurchen and Korean spellings in historical sources, dictionaries and related studies.

Ном зүй

- Bregel Y.** 1996. *Notes on the Study of Central Asia*. Papers on Inner Asia. No. 28. Bloomington: Indiana University Research Institute for Inner Asian Studies.
- Campbell, Cameron, Lee, James Z., and Elliott, Mark.** 2002. "Identity Construction and Reconstruction: Naming and Manchu Ethnicity in Northeast China, 1749–1909," *Historical Methods: A Journal of Quantitative and Interdisciplinary History* 35:3 (2002), 101-115.
- Crossley, Pamela.** 1999. *A Translucent Mirror: History and Identity in Qing Imperial Ideology*. Berkeley, London: University of California Press.
- Di Cosmo, Nicola.** 2016. "The Extension of Ch'ing rule over Mongolia, Sinkiang, and Tibet, 1636-1800". In *The Cambridge History of China: Vol. 9. Part Two: The Ch'ing Dynasty to 1800*. Eds. Willard Peterson. Cambridge University Press: Cambridge. 111-145.
- Elliott, Mark.** 2001. *The Manchu Way: The Eight Banners and Ethnic Identity in Late Imperial China*. Stanford, California: Stanford University Press.
- Gorelova, Liliya.** 2002. *Manchu Grammar*. Leiden: Brill.
- Gorski.** 1858. *Über die Herkunft des Stammvaters der jetzt in China herrschenden Dynastie Zin und vom Ursprung des Namens der Mantschu*, Arbeiten der Kaiserlich Russischen Gesandtschaft zu Peking über China, sein Volk, seine Religion, seine Institutionen, socialen Verhältnisse etc, vol. 1, Berlin: F. Heinicke.
- Grupper, Samuel.** 1989. "Manchu Patronage and Tibetan Buddhism during the first half of the Ch'ing Dynasty". *Journal of the Tibet Society*, 4: 47-75.
- Gu, Ming Dong.** 2003. "Literary Openness: A Bridge across the Divide between Chinese and Western Literary Thought". *Comparative Literature*, Vol. 55 (2): 112-129.
- Han-i araha sunja gisun-i hergen qamciha buleku bidhe (Хааны бичсэн Таван зүйлийн үсэг хавсарсан толь бичиг). 1957. Beijing: Ündüsün-ü keblel-ün qoriy-a.
- Hauer, Erich (trans.).** 1926. *Huang Qing kaiguo fanglue* (皇清開國方略), Berlin and Leipzig: Walter de Gruyter&Co.
- Huang, Pei.** 1990. *New Light on The Origins of The Manchus*. HJAS, Vol. 50, No.1 (Jun.): 239-282.
- Hummel, Arthur ed.** 1964. *Eminent Chinese of the Ch'ing Period*, (1944-1912), Originally printed by US Government Printing Office, Washington, 1943-44, Reprint. Taipei: Literature House, LTD.
- Jiu manzhou dang* (Дусал бинтгүй үсгийн данс). 1969. Taipei: Palace Museum.
- Jongtae, Lim.** 2016. "Tributary relations between the Choson and Ch'ing courts to 1800". In *The Cambridge History of China: Vol. 9. Part Two: The Ch'ing Dynasty to 1800*. Eds. Willard Peterson. Cambridge: Cambridge University Press. 146-198.
- Lattimore, Owen.** 1951. *Inner Asian Frontiers of China*. New York: Capitol Publishing Company.
- Lee, Robert H.G.** 1970. *The Manchurian Frontier in Ch'ing History*. Cambridge: Harvard University Press.
- Lin, T.C.** "Manchuria in the Ming empire". *Nankai Social and Economic Quarterly*, 8, No. I (April 1935), pp. 1-43;
- Lubsangjab Choi., Će. Siraküü.** 1968. *Manju mongyol toli biĉig*. Ulaŋanbayatur: Sinjilekü uqayan-u akademi-yin keblekü üyiledbüri.
- Manzhou yuan liu kao** (滿洲源流考), Agüi et al., eds., 1783, reprint: 1988. Shenyang (沈阳): Liaoning minzu chubanshe (辽宁民族出版社).
- Michael, Franz.** 1965. *The Origin of Manchu Rule in China: Frontier and Bureaucracy as Interacting Forces in the Chinese Empire*. New York: Octagon books. INC.

- Millward, James.** 2004. "Qing Inner Asian empire and the return of the Torghuts". *New Qing Imperial History*. Eds. James Millward, Ruth Dunnell, Mark Elliot and Philippe Forêt. London and New-York: Routledge. 91-108.
- Norman, Jerry.** 2003. "The Manchus and their language". *Journal of American Oriental Society*. Vol 123. No.3 (Jul-Sep.): 483-491.
- Pang, Tatiana., Stary, Giovanni.** 1998. *New Light on Manchu historiography and Literature: The Discovery of three documents in Old Manchu script*. Wiesbaden: O. Harrassowitz.
- Ross, John.** 1973. *The Manchus. The Reigning Dynasty of China: Their Rise and Progress*. First AMS edition London 1891. Repr. New York: AMS Press Inc.
- Roth Li, Gertraude.** 1975. *The Rise of the Early Manchu State: A Portrait drawn from Manchu Sources to 1636*, Ph.D thesis, Harvard University.
- Sanjirō, Ichimura.** 1939. 支那史研究 (Shinashi kenkyū), Tokyo: 春秋社 (Shunjusha).
- Serruys, Henry.** 1955. *Sino-Jürčed relations during the Yung-Lo period, (1403-1424)*, Wiesbaden: O. Harrassowitz.
- Shirokogorov, Sergei.** 1924. *Social organization of the Manchus. A study of the Manchu clan organization*, Royal Asiatic society, North China branch Shanghai.
- Stary, Giovanni.** 1984. "The Manchu Emperor Abahai: Analysis of an Historiographic mistake". *CAJ* 28.
- Stary, Giovanni.** 1990a. *Manchu Studies, An International Bibliography*, 3, Indices, Otto Harrassowitz, Wiesbaden.
- Stary, Giovanni.** 1990b. The Meaning of the Word 'Manchu': A New Solution to an Old Problem, *Central Asiatic Journal*, Vol. 34, Nos. 1-2.
- Sun L.** 2017. *Writing an empire: an analysis of the manchu origin myth and the dynamics of manchu identity..* *Journal of Chinese History 中國歷史學刊*, 1(1), 93-109. doi:10.1017/jch.2016.4
- Wilkinson, Endymion.** 2000. *Chinese History: A Manual*. Cambridge Massachusetts: Harvard University Asia Center.
- Саган сэцэн.** 2006. *Эрдэнийн товч*, Улаанбаатар: Соёмбо пресс.
- Шаарийбуу Я.** 1999. *Манж утга зохиолын дээж*. Улаанбаатар: Адмон.